



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

152 /152/

2021.10.08

Үйл явдал

Түүхэнд энэ өдөр

2009 он:

Монгол-Катар Улсын Зэвсэгт хүчний хамтарсан хээрийн сургалт, дадлагыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулав.

"ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙХЭН НЭГДЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хурэлсүхийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд Батлан хамгаалах яам, түүний харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд туйлын идэвх зүтгэлтэй хамрагдаж байна.

Нээлтийн ёслолын ажиллагааны эхэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо үг хэлсэн бөгөөд тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг манай улсын төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, иргэд талархан өргөн хүрээтэй дэмжиж байна.



дагуу болон онцгой шаардлагатай газар, районд мод тарих, арчлах, ургуулах чиглэлээр хийх ажлуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийлээ.

Энэхүү нээлтийн ёслолын дараа Зэвсэгт хүчний Жанжин штаб, Батлан хамгаалахын төв архив, ЦДБЭЧ,

"Багабаян" ТӨҮГ, "ТВ5" телевиз, МЦНХ-ны удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл хөтөч нарын хамтаар хариуцуулан өгсөн газруудад мод тарих ажилд идэвхтэй хамрагдсан юм.

Хурандаа Б.ОТГОНБАЯР



Зэвсэгт хүчний мод үржүүлгийн төвд зохион байгуулсан нээлтийн ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх, бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба, Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг нарын хүндэт зочид оролцлоо.

Түүний дотор Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн чухал үүрэг, оролцоотой байж, олон бүтээлч ажлыг санаачлан хэрэгжүүлж байгааг онцолсон юм.

Мөн БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа С.Ганбямба нар Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд мод тарих, ургуулах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлууд, цаашид төмөр зам, авто зам

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
8	-3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,851.00
EUR	3,259.0	3,324.0
CNY	440.00	443.60
RUB	38.80	40.50
JPY	25.26	25.83
KRW	2.31	2.44

ЗУРХАЙ

2021.10.08 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 2/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ЗУРГААН ЦАГААН ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингих:

07.01-18.18

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал:

Шороо

Аргын тооллын 10 сарын 8, Сугар гараг. Билгийн тооллын 2, Салхины эх одтой, шарагчин үхэр өдөр. Өдрийн наран 7 цаг 01 минутад мандан, 17 цаг 18 минутад жаргана. Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адуус номхруулах, мал арилжих, буг дарах, газрын ам бооход сайн. Байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Хүйтэн шүүдэр буух улирал (11 цаг 05 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

АНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ



Зэвсэгт хүчний 339 дүгээр анги

ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн үйл ажиллагаатай танилцлаа.

Түүнийг ангийн байрлалд ирэхэд Баянхонгор цэргийн хүрээний хүндэт харуул угтаж авсан юм.

Хөтөлбөрийн дагуу ангийн захирагч, хурандаа Ц.Батхүү хийж хэрэгжүүлсэн ажил, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал болон

тулгамдаж буй асуудлын талаар илтгэж танилцуулсан.

Мөн ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, ЗХЖШ-ын Материал, техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр нар ангийн байрлал, барилга байгууламжийн ашиглалт, чанар байдалтай танилцсан бөгөөд ангийн удирдлага нарт тодорхой үүрэг чиглэл өгсөн юм.

Үйл ажиллагааны төгсгөлд ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг ангийн байнгын бие бүрэлдэхүүнтэй

уулзаж Зэвсэгт хүчний шинэчлэл, цаашид баримтлах бодлого, чиглэлийн талаар мэдээлэл хийж шинэ цагийн Зэвсэгт хүчний офицер, ахлагч нар төрийн албаны болон офицер, ахлагчийн ёс зүйг ягштал баримталж, сахилгын зөрчилгүй, хариуцлагатай, шинийг санаачилсан, бие даан сурч өөрийгөө хөгжүүлж хандлагаа өөрчлөх нэн шаардлагатай байна гэж хэлсэн юм.



Ахмад С.АМАРЖАРГАЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
313.511 +2237

ЭДГЭРСЭН
363.881 +1107

НАС БАРСАН
1387 +15

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
5448 +95

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
197

ЭДГЭРСЭН
5145

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 237,048,218

Эдгэрсэн

Нийт: 214,187,571

Нас барсан

Нийт: 4,839,383

Цахим шууданд

"БӨРТЭ" ISO 9001:2015 СТАНДАРТАД ШИЛЖИНЭ

"БӨРТЭ" ТӨҮГ ирэх жил 100 жилийн босгыг давна. Уг түүхэн ойг угтаж тодорхой ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлж байгаагийн нэгэн илрэл нь тус байгууллага ISO 9001:2015 олон улсын чанарын менежментийн тогтолцоонд шилжих анхны алхмаа хийж буй явдал юм. Эхний ээлжинд тус үйлдвэр ISO 9001:2015 стандарттай харьцуулахад ямар түвшинд үйл ажиллагаа явуулж байгааг судалж, цаашлаад гурван сарын хугацаанд тус стандартад нийцсэн удирдлагын тогтолцоог бий болгохоор ажиллах юм байна. Ингэснээр батлан хамгаалах салбартаа дээрх олон улсын стандартад шилжсэн анхдагч байгууллага болох боломжтой аж. "БӨРТЭ" ТӨҮГ-ын ерөнхий захирал, хурандаа Д.Энхтайваны хэлснээр "Манай байгууллага энэхүү стандартад



шилжсэнээр зардлаа хэмнэж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа, ажиллах процесс, ажилчдын уялдаа холбоогоо илүү сайжруулж чадна. Ингэснээр хэрэглэгчдийн эрэлтэд нийцсэн чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чадамжаа дээшлүүлнэ. Дээрээс нь хэрэглэгчдийн сэтгэл санаанд илүү нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлээд ирэхээр зах зээл, бизнесийн талбар маань өргөжиж, цаашлаад олон улсын жишигт нийцсэн оёдлын үйлдвэр болох бүрэн боломжтой" гэлээ.

АХМАД ДАЙЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Зэвсэгт хүчний 100 жил, Чөлөөлөх дайны ялалтын 76 жил, "Олон улсын ахмадын өдөр"-ийг тохиолдуулан 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайн, 1940-1948 оны Улсын баруун хилийн тулгаралтад оролцсон ахмад дайчдад 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүндэтгэл үзүүллээ. Энэ үеэр 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон Завхан аймгийн Улиастай сумын иргэн ахмад дайчин Гунгаасамбуугийн Гоодриг, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон Завхан аймгийн Идэр сумын иргэн ахмад дайчин Далантайн

Лхамжав, Улсын баруун хилийн тулгаралтад оролцсон Завхан аймгийн Цагаан чулуут сумын иргэн ахмад дайчин Самбуугийн Түмэнбилэг нарт цэргийн алба хаагчид ангийн байлдааны тугтайгаар очиж хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг ёслол төгөлдөр зохион байгуулсан юм.

Ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх үеэр Завхан аймгийн Идэр сумын Засаг дарга Т.Ууганбаатар, Цагаан чулуут сумын Засаг дарга Г.Бат-Эрдэнэ нар болон орон нутгийн ард, иргэд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн хамт олонд талархал илэрхийлж байлаа.

Ахмад Н.МӨНХБААТАР

30 КМ-ЫН ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ

"БНӨСУ"-д үүрэг гүйцэтгэх Мотобуудлагын батальоны ажиллагааны удирдлагын тасаг, энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн багш нартай хамтран 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдөр салааны жигдрэлт сургалтын төгсгөлд 30 км-ын явган маршийг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Маршаар цаг агаарын ямар ч нөхцөлд тавигдсан үүргийг биелүүлэх тэсвэр хатуужлыг бие бүрэлдэхүүнд олгож, сэтгэл зүйн тогтвортой байдлыг ханган, салаа, ротын захирагч нарын тактик сэтгэлгээг хөгжүүлэх, гэнэт үүссэн цагийн байдалд шийдвэр гаргах арга ажиллагаанд дадлагажуулан явууллаа.



Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Зэвсэгт хүчний 353 дүгээр анги

2021 оны Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын хэмжээнд явагдаж өнгөрсөн цэрэгжлийн спортын "Цэрэгжлийн буудлага", "Цэргийн 3 төрөлт", "Саадын зурвас", "ЦСЦН-ын зуны 5 төрөлт", "Цэрэгжлийн гямнастик"-ийн тэмцээнүүдэд Зэвсэгт хүчний 353 дугаар ангиас нийт 25 баг тамирчин орсноос "Саадын зурвас" тэмцээний эмэгтэйчүүдийн төрөлд ахлах дэслэгч Т.Бизъяа, дэд ахлагч Б.Отгон-Эрдэнэ нар багаараа хүрэл, цэрэгжлийн гимнастикийн олон төрөлтийн тэмцээний дүүжингийн төрөлд ахлах дэслэгч Б.Отгонбаатар алтан медаль хүртсэн амжилт үзүүлжээ.

Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ

ИХ ГОВИЙН ГАРНИЗОН ИХ ҮЙЛСИЙН ТЭРГҮҮН ФРОНТОД

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Зүүнбаян-Таван толгой" чиглэлийн төмөр зам дагуу мод тарьж,



ургуулах ажлыг "Эрдэнэс Таван толгой" ХХК-ийн санхүүжилтээр ЗХЖШ-ын гүйцэтгэлээр хийгдэх "Сая тонн-Сая мод" хөтөлбөр 10 дугаар сарын 7-ны өдөр Дорноговь аймгийн Зүүнбаян тосгонд нээлтээ хийлээ. Энэхүү арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, УИХ-ийн гишүүн Н.Наранбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, "Эрдэнэс Таван толгой" ХХК-ий гүйцэтгэх захирал Б.Ганхуяг, ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын

генерал Ч.Цогтжаргал нар болон албаны бусад хүмүүс оролцлоо. Тус төслийн тэргүүн эгнээнд Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн бүрэлдэхүүн идэвхийлэн оролцлоо.



ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭСТЭЙ ХАМТРАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

БЗД-ийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран 2021 оны 10 дугаар сарын 6-нд "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх", "Эмнэлгийн анхан шатны тусламж" сургалтыг танхимаар болон цахимаар бие бүрэлдэхүүнтэй зохион байгуулан явууллаа.

Сургалтаар гамшгаас хамгаалах болон аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм, утаат орчноос аврах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон яс хугарах, усанд живэх, үе мултрах, амилуулах суурь тусламж, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх талаар дадлага сургалтыг үр дүнтэй зохион байгууллаа.

Ахлах дэслэгч М.ОЧГЭРЭЛ



ОФИЦЕР, АХЛАГЧИЙН ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА

Зэвсэгт хүчний 339 дүгээр анги

Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/107 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг явуулах журам"-ын дагуу ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн 2021

оны 9 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид ажиллаж, түвшин тогтоох үзлэгийг зохион байгуулав.

Офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгт ангийн бие бүрэлдэхүүн төдийгүй Баянхонгор, Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын бие бүрэлдэхүүн хамрагдаж хүн нэг бүрийн ажлын гүйцэтгэлийн үр

дүн, албаны хандлагыг дүгнүүлж, мэргэжлийн үр чадвар, багаар ажиллах чадвараа хамт олноороо үнэлүүлэн, сэтгэл зүйн бэлтгэлжилт, эрүүл мэндийн байдлаар цэргийн жинхэнэ албанд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхээ тогтоолгож, цаашид анхаарах шаардлагатай чиглэлээ тодорхойлж авлаа.

Тус ангийн бие бүрэлдэхүүн бүтээн байгуулалтын ажлын хажуугаар түвшин тогтоох үзлэгийн бэлтгэлийг хангаж, хүн нэг бүрийн бүрдүүлэх баримт бичгийг зааврын дагуу боловсруулж, жигдрэлтийг хангасан нь комиссын бүрэлдэхүүн үзлэгийг богино хугацаанд үнэн зөв, бодитой үнэлэн, үр дүнтэй зохион байгуулахад дөхөм байсан юм.

